

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Хөлөнбуйр хөгжил” ОНӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2026/023/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Дорнод аймаг 2026 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: Д.Нармандах Утас: 7058-4207 Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	Error! Bookmark not defined.
4. АУДИТЫН ТАЙЛАН	Error! Bookmark not defined.
4.1 Ерөнхий зүйл	Error! Bookmark not defined.
4.2 Материаллаг байдал.....	Error! Bookmark not defined.
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	Error! Bookmark not defined.
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	Error! Bookmark not defined.
4.5 Ерөнхий чиглэлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим сорилын үр дүн	Error! Bookmark not defined.
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .	Error! Bookmark not defined.
4.5.1 Завсрын аудитын талаар.....	Error! Bookmark not defined.
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	Error! Bookmark not defined.
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	8
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .	Error! Bookmark not defined.

Товчилсон үгийн жагсаалт

АДБООС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААТҮГ	Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
УСНББООС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг
Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
Утас: 7058-4203

АДБ. 03.13 № 158
танай _____-ны № _____-т

“ХӨЛӨНБУЙР ХӨГЖИЛ” ОНӨҮГ-ЫН
ДАРГА У.ЭРДЭНЭБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Хөлөнбуйр хөгжил” ОНӨҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус байгууллага нь нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч бөгөөд борлуулалтын орлогод ногдох нэмэгдсэн өртгийн албан татвар, худалдан авалтын хасагдах татварын хэмжээг салгаж бүртгэдэггүй, тайлант хугацаанд үүссэн татварын авлага, өрийг татварын системд үүссэн дүнтэй тулгаж, тооцоо нийлж баталгаажуулдаггүй байна.

Аудитын гол асуудлууд

Тус байгууллага нь орон нутгийн төсвөөс санхүүжилт авч үйл ажиллагаагаа явуулдаг ба нийт орлого 100,563.4 мянган төгрөгийн орлого орсноос 28,476.4 мянган төгрөг буюу 28.3 хувь нь өөрийн үйл ажиллагааны орлогоос бүрдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Компанийн жилийн төлөвлөгөөнд зорилт, арга хэмжээ төлөвлөдөггүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

2126050196

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Хөрөнгө		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	5,422,750.59	59,057.28
1.1.2	Дансны авлага	-	-
1.1.6	Бараа материал	-	2,000,000.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	5,422,750.59	2,059,057.28
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,169,080,140.87	1,100,303,119.65
1.2.2	Биет бус хөрөнгө	-	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,169,080,140.87	1,100,303,119.65
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,174,502,891.46	1,102,362,176.93
2.1.1.1	Дансны өглөг		1,756,000.00
2.1.1.3	Татварын өр		6,909,241.61
2.1.1.2	Цалингийн өглөг		1,166,980.00
2.1.1.4	НДШ өглөг		1,382,730.79
2.1.1.12	Бусаад богино хугацаат өр төлбөр		5,435,036.20
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	-	16,649,988.60
2.2	Өр төлбөрийн нийт дүн		
2.3	Өмч		
2.3.1	төрийн		
2.3.2	хувийн		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	1,174,502,891.46	1,085,712,188.33
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,174,502,891.46	1,085,712,188.33
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,174,502,891.46	1,102,362,176.93

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	14,988,657.00	25,330,000.00
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	-
3	Нийт ашиг (алдагдал)	14,988,657.00	25,330,000.00
4	Түрээсийн орлого	4,004,000.00	3,146,400.00
5	Хүүний орлого	-	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	118,738,750.00	72,087,000.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	167,078,847.64	154,976,122.27

10	Ерөнхий ба удирдлагын зардал	54,912,612.08	34,377,980.86
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	-	-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(84,260,053.32)	(88,790,703.13)
19	Орлогын татварын зардал	-	-
20	Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(84,260,053.32)	(88,790,703.13)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	(84,260,053.32)	(88,790,703.13)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	1,258,500,944.78	1,258,500,944.78
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	-	1,258,500,944.78	1,258,500,944.78
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	(84,260,053.32)	(84,260,053.32)
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
7	Зарласан ногдол ашиг	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-
9	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	1,174,502,891.46	1,174,502,891.46
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	-	(88,790,703.13)	(88,790,703.13)
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
15	Зарласан ногдол ашиг	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-

17	2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	1,085,712,188.33	1,085,712,188.13
----	--	---	------------------	------------------

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн	137,731,407.00	100,563,400.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	18,650,600.00	28,476,400.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
	Татаас санхүүжилтын орлого	112,413,000.00	72,087,000.00
	Бусад мөнгөн орлого	6,667,807.00	
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	137,524,223.68	105,927,093.31
1.2.1	Ажиллагчдад төлсөн	35,157,941.97	51,548,416.26
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-	-
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	-	-
1.2.4	Ашиглалтын зардал төлсөн	102,366,281.71	54,378,677.05
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	-	-
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-	-
1.2.9	Бусад мөнгөн зарлага	-	-
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	207,183.22	(5,363,693.31)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн	-	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн	-	-
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
3	Санхүү үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн	-	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Валютын ханшийн зөрүү	-	-
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	207,183.32	(5,363,693.31)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,953,567.27	5,422,750.59
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,160,750.59	59,057.28

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

(төгрөгөөр)

Үзүүлэлт	2024 оны гүйцэтгэл	Зөрүү			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
Үндсэн үйл ажиллагааны орлого	18,992,657.00	-	28,476,400.00	28,476,400.00	
Татаас санхүүжилт	118,738,750.00	76,000,000.00	72,087,000.00	(3,913,000.00)	(5.15)
НИЙТ ОРЛОГЫН ДҮН	137,731,407.00	76,000,000.00	100,563,400.00	28,476,400.00	37.47
Цалин хөлс	24,643,154.00	40,000,000.00	38,825,121.00	(1,174,879.00)	(2.94)
Байгууллага НДШ зардал	9,124,436.97	-	12,723,295.26	12,723,295.26	
Хангамжийн бараа материалын зардал	103,756,632.71	36,000,000.00	61,528,665.75	25,528,665.75	70.91
Элэгдлийн зардал	84,467,236.64	-	76,277,021.22	76,277,021.22	
НИЙТ ЗАРДЛЫН ДҮН	221,991,460.32	76,000,000.00	189,354,103.23	113,354,103.23	149.15
ТАТВАР	-	-	-	-	-
ТАТВАРЫН ДАРААХ АШИГ	-84,260,053.32	0.00	-88,790,703.23	-84,877,703.23	

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,995.4 мянган төгрөгийн зөрчил¹-д 5,995.4 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгөв.

5.1 Албан шаардлага

Зардлыг түүвэрлэн ибаримттай тулгахад шатахуун зардалд 10,443.4 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч 5,995.4 мянган төгрөгийг худалдан авалтын цахим баримтаар баталгаажуулах нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Татварын бүртгэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч бөгөөд борлуулалтын орлогод ногдох нэмэгдсэн өртгийн албан татвар, худалдан авалтын хасагдах татварын хэмжээг салгаж бүртгэдэггүй, тайлант хугацаанд үүссэн татварын авлага, өрийг татварын системд үүссэн дүнтэй тулгаж, тооцоо нийлж баталгаажуулдаггүй нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т "Үйл ажиллагааны борлуулалтын орлогын хэмжээ нь 50 сая ба түүнээс дээш төгрөгт хүрч, албан татвар ногдуулан суутган авч, төсөвт төвлөрүүлэх үүрэг бүхий дараах этгээд албан татвар суутган төлөгч байна", 14 дүгээр зүйлийн 14.1-д "Хувь хүн, хуулийн этгээдийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлснээс хойших

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

Commented [NA1]: нягтлах

Commented [D2R1]: засав

хугацаанд энэ хуулийн 7, 8, 11 дүгээр зүйлд заасны дагуу төлсөн доор дурдсан албан татварыг түүний төсөвт төлөх албан татвараас хасаж тооцно”, Нягтлан болох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7-д “Аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө тусалцаа авах” гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.7 дахь заалтыг баримтлан, орлого, худалдан авалтад ногдох нэмэгдсэн өртгийн албан татварыг салгаж бүртгэх.

2. Гэрээ байгуулахтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Байгууллагын удирдлага нь дээд шатны байгууллагатай гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулж, тайлангаа дүгнүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д “Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах”, 16.5.2-т “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлыг / цаашид "захирал" гэх/ томилохдоо гэрээ байгуулна. гэрээнд дараах нөхцөлийг тусгана” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

11/ гэрээний үүргийн биелэлтийг дүгнэх журам, хугацаа

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.7 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалтуудыг баримтлан, дээд шатны захирагчтай үр дүнгийн гэрээ байгуулж ажиллах

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын байгууллагад 30 хоногийн дотор, харин зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Зардлыг түүвэрлэн ибаримттай тулгахад шатахуун зардалд 10,443.4 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч 5,995.4 мянган төгрөгийг худалдан авалтын цахим баримтаар баталгаажуулдаггүй	1	5,995.4			1	5,995.4						
Дүн	1	5,995.4			1	5,995.4	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар												
Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч бөгөөд борлуулалтын орлогод ногдох нэмэгдсэн өртгийн албан татвар, худалдан авалтын хасагдах татварын хэмжээг салгаж бүртгэдэггүй, тайлант хугацаанд үүссэн татварын авлага, өрийг татварын системд үүссэн дүнтэй тулгаж, тооцоо нийлж баталгаажуулдаггүй	1	-					1	-				
Байгууллагын удирдлага нь дээд шатны байгууллагатай гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулж, тайлангаа дүгнүүлээгүй	1	-					1	-				
Дүн	2	-					2	-	-	-	-	-